

Сонгино-хайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг

1982 онд Октябрийн районы Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн бааз суурин дээр суурилан, СнЗ-ийн тогтоол ЭМЯ-ны Сайдын тушаалын дагуу хүүхдийн нэгдсэн 3 дугаар эмнэлэг байгуулагдсан түүхтэй.

1982 оны 26 тоот тушаалаар захиргааны анхны зөвлөлийн гишүүдийг томилсон.

Монгол Улсын эрүүл мэндийн сайд нийслэлийн засаг даргын 2001 оны 98/197 тоот тушаал захирамжаар Сонгино-хайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг байгуулагдсан түүхтэй, тус нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмчээр 1982-1991 онд анагаах ухааны доктор Б.Барай, 1991-1993, Ш.Оюунчимэг, 1993-2000 онд, Э.Буянмандах, 2000-2003 онд анагаах ухааны доктор П.Янсан, 2003 оноос Б.Галсанцэдэн ажиллаж байна.

Орны тоо хучин чадал

1982 онд 120 ортой

1983 онд 175 ортой

1990 онд 118 ортой

2003 онд 115 ортой болсон.

Хүүхдийн нэгдсэн эмнэлэг Эрүүлийг хамгаалах яамны сайдын 1982 оны 275, Хотын Эрүүлийг Хамгаалах газар, Ардын Бүгд хурлын 1982 оны 154/115 тоот тушаалуудыг хэрэгжүүлэх шийдвэр гаргаж ерөнхий боловсролын сургуулийн эмчийн ажиллах заавар, заавал хийж гүйцэтгэх ажлын жагсаалтыг мөрдүүлэх, сургуулийн эмчийн сарын ажлын мэдээ, хүүхдийн өвчлөлтийн мэдээг сар бүр авах, хүүхэд шүд, чих хамар хоолой, нүдний эмчийн бүрэлдэхүүнтэй эрүүлжүүлэх, явуулын группийг сургуулиудад оны эхнээс ажиллуулах, жил бүрийн 4-р улиралд багтаан графикайн дагуу 1,3,8,10-р ангийн бүх сурагчдыг шүд чих хамар хоолой, нүд, мэдрэлийн мэргэжлийн эмч нарын үзлэгт заавал оруулж, өвчтэй илэрсэн хүүхдийг диспансерийн хяналтад авах, эрүүлжүүлэх ажлын байдлаар тэдний ажлыг дүгнэх, эдгээр ажлыг поликлиник хариуцахаар тогтоожээ.

Тус эмнэлгийн хөгжлийг 3 үед хуваан авч үзвэл

1. Эмнэлэг байгуулагдсан эхний үе шат / 1982-1990/
2. Эмнэлгийн эрчимтэй хөгжлийн үе /1990-2000/
3. Сонгино-хайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг дахин мэндэлж хөгжиж байгаа үе /2001-2008/

Сонгино-хайрхан дүүрэг байгуулагдахад Октябрийн районы нэгдсэн эмнэлэг нь СХД-н Нэгдсэн эмнэлэг гэж нэрлэгдэж байгаад 1995 оноос Октябрь Эрүүл мэндийн зөвлөх төвтэй улмаар 1997 оноос дүүргийн эрүүл мэндийн нэгдэлтэй тус тус нэгдэж, 2001 оноос хүүхдийн нэгдсэн 3-р эмнэлгийг Эрүүл мэндийн сайд Нийслэлийн Засаг даргын хамтарсан шийдвэрээр дүүргийн Нэгдсэн эмнэлэг болгон дахин мэндэлсэн.

СХД-ийн 19 хорооны 21 хороололд эмнэлгийн зориулалтын иж бүрдэл 3 давхар барилгатай, 120 орны хүчин чадалтай төвлөрсөн халаалт усан хангамжтай, зориулалтын гал тогоо, архив, бие даасан 6 туслах барилгын объекттой 18907 м/кв талбай бүхий хашаатай.

Одоогийн байдлаар нийт 115 ортой, сэхээний 5, насанд хүрэгчдийн болон хүүхдийн 55 ортой. Хүүхдийн өвчний чиглэлээр СХД-ийн 25 хороо БГД-н 1,7,20 хороо нийт 33 хорооны 0-16 насны 75000 гаруй хүүхдэд, СХД-н 50 гаруй мянган насанд хүрэгчдэд нийт 125000 гаруй хүн амд эмнэлгийн 2-р шатлалын хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг үзүүлдэг.

Эрчимт эмчилгээ, сэхээн амьдруулах, хүүхдийн, насанд хүрэгчдийн үндсэн 3 тасаг, дэмжих үйл ажиллагааны пара-клиник, захиргаа, аж ахуйн туслах 3, нийт 6 тасагтай үйл ажиллагаагаа явуулж байна. Пара-клиникийн тасагт эмийг сан, рентген, хэт авиан оношлог-оо, лаборатори, Грам, угаалга, ариутгал, патанатом, гэх мэт тасаг нэгжүүд орно.